



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

“ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ БА ШИЙДЭЛ” 2025-11-20

ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Д. Кадирбек /PhD/

ХААИС-ийн ЭЗБС-ийн
Менежментийн тэнхим

• Товч танилцуулга



- ХААИС-ийн ЭЗБС-ийн Менежментийн тэнхимийн эрхлэгч
- Нидерландын Вант Улсын Вагенингений их сургуульд “Dutch Disease in Mongolia: Mining sector dependence and strategies for diversification” сэдвээр докторын зэрэг хамгаалсан.
- Өндөр зэрэглэлийн, нөлөөлөл бүхий сэтгүүлд 9 өгүүлэл нийтлүүлсэн.
- Судалгааны ажлын чиглэл:
 - Эдийн засгийг төрөлжүүлэх асуудал
 - Хөдөө аж ахуй, мал аж ахуйн эдийн засаг, менежмент, стратеги, бүтээмж, үр ашиг, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ
 - Хүнсний аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал
 - Малчин өрхийн нийгэм, эдийн засаг, амьжиргаа, хамтын ажиллагаа, хандлага
 - Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, эрсдэл, даван туулах арга зам

• Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт

Салбаруудын өсөлт
/2020 - 2024/

Уул уурхай	➡ 24.1 - 27.9% (3.8% ↑)
Хөдөө аж ахуй	➡ 12.8 - 7.5% (5.3% ↓)
Боловсруулах үйлдвэр	➡ 9.2 - 6.6% (2.6% ↓)

Нийт экспорт /2024/

Уул уурхай	➡ 92%
Хөдөө аж ахуй	➡ 4%
Боловсруулах үйлдвэр	➡ 4%

Эх үүсвэр. YCX, Гаалийн ерөнхий газар

• Эдийн засгийн төрөлжилт

Төрөлжилт /2020 - 2024/

Экспортын бүтээгдэхүүн	➡ 103 (143) - 130 (140) (3↑)
Экспортын төвлөрлийн индекс	➡ 0.41 (145) – 0.46 (163) (18↓)
Экспортын төрөлжилтийн индекс	➡ 0.87 (207) – 0.85 (201) (6↑)

Эх үүсвэр. <https://unctadstat.unctad.org/>

- Нэг салбараас хараат байдал:



- Голланд өвчин
- Баялгийн хараал



- Судалгааны ажлын зорилго:
- Уул уурхайн бус боловсруулах салбарыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, санал боловсруулах

• Арга зүй

Харьцангуй давуу талын индекс

$$RCA_{Ai} = \frac{X_{Ai} / \sum_{j \in P} X_{Aj}}{X_{wi} / \sum_{j \in P} X_{wj}}$$

RCA_{Ai} - A улсын i бүтээгдэхүүний харьцангуй давуу талын индекс

P - барааны бүлэг, үүнд $i \in P$

X_{Ai} - A улсын i бүтээгдэхүүний экспорт

X_{wi} - i бүтээгдэхүүний дэлхийн экспорт

$\sum_{j \in P} X_{Aj}$ - A улсын нийт экспорт (P бүлгийн бүх бүтээгдэхүүний)

$\sum_{j \in P} X_{wj}$ - дэлхийн нийт экспорт (P бүлгийн бүх бүтээгдэхүүний)

Уул уурхайн
бус салбарын
үнэ цэний
сүлжээ

Оролцог-
чид

Үйлдвэр- лэгчид Тээвэр, логистик	Боловсруу- лагчид Хоршоо Зуучлагчид	Экспортын болон дундын зуучлагчид	Бөөний худалдаачид	Дотоодын зах зээл Олон улсын зах зээл	
Орох урсгал Үндсэн үйл ажиллагаа	Боловсруу- лалт	Гарах урсгал	Маркетинг, борлуулалт	Үйлчилгээ	

Үнэ цэн
нэмэгдэх



• Өгөгдөл

1. Олон улсын худалдааны төв (ИТС)-ийн HS4 ангиллын код бүхий 870 бүтээгдэхүүний экспортын үнийн дүн
2. Нийт экспортын үнийн дүн
 - Дэлхий
 - Монгол Улс
 - Казахстан
 - Киргизстан
3. Өмнө нь хийгдсэн судалгааны ажлуудаас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний шат бүрд тулгарах бэрхшээлүүд – 50 бүтээл




• Харьцангуй давуу талын индексийн шинжилгээний үр дүн

• 42 бүтээгдэхүүн $\Rightarrow$ 19 ҮЦС: 12 (15) УУ, 4 (4) ГТ, **3 (24) МАА**



• Мал аж ахуйн салбарын нэгдсэн үнэ цэний сүлжээний зураглал





• Мал аж ахуйн салбарын үнэ цэний сүлжээний шат бүрд тулгамдсан асуудлууд

Үйлдвэрлэлийн орц нийлүүлэлт	Логистикийн орох урсгал, хадгалалт	Боловсруулалт	Логистикийн гарах урсгал, хадгалалт	Хэрэглээ
- Бэлчээрийн малын бүтээгдэхүүний гарц, бүтээмж бага. - Байгаль, цаг уураас бүрэн хараат, эрсдэлд өртөмтгий. - Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ хямд, заримыг нь худалдан авах хүнгүй болохоор бараг үнэгүй. - Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт их, ялангуяа экспортын хориг бүхий өвчин гардаг. Мал эмнэлгийн үйлчилгээ хангалтгүй. - Мал аж ахуйн болон эрүүл ахуйн зохистой дадал, мал төхөөрөх стандарт, дадлуудыг бага мөрддөг нь түүхий эд, бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлдөг.	- Өргөн уудам нутаг дэвсгэртэй, боловсруулах үйлдвэрүүд төвийн бүсэд төвлөрснөөс түүхий эд цуглуулах, хадгалах, тээвэрлэх зардал өндөр. - Дэд бүтцийн хөгжил сул, дотоодын төмөр замын сүлжээ зөвхөн Улаанбаатарыг дайруулаад БНХАУ ба ОХУ-ыг холбох үүрэгтэй тул түүхий эдийг автомашинаар тээвэрлэдэг нь өртөг нэмэгдүүлдэг. - Орон нутагт түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх, технологийн дагуу хадгалах түүхий эдийн төв, агуулах дутмаг. - Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлтийн зохистой дадал, стандартыг бага мөрддөг.	- Үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадал, хүнсний аюулгүй байдлын стандартууд, импортлогч орнуудын шаардлагуудыг хангаж чаддаггүй. - Үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмж хоцрогдсон, үйлдвэрлэгчдийн хөрөнгө оруулалт хийх чадавх сул. - Ихэнх ажиллагчид цалин өндөртэй уул уурхайн салбарт ажиллах сонирхолтой байдаг тул хөнгөн, хүнсний үйлдвэрүүдэд ажиллах хүчний нөөц бүрдүүлэхэд сөрөг нөлөөлдөг. Үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн шатанд стандарт мөрддөггүйгээс их хэмжээний хаягдал гардаг.	- Хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүний стандарт, технологийн дагуу хадгалах түүхий эдийн төв, агуулах дутмаг. - Хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн зохистой дадал, стандартыг бага мөрддөг. - Дэд бүтцийн хөгжил сул, бэлэн бүтээгдэхүүнийг ихэнхдээ автомашинаар тээвэрлэдэг нь өртөг нэмэгдүүлдэг.	- Импортлогч орнуудын тарифын болон тарифын бус хязгаарлалтууд, саад тотгорууд ихтэй. - Хоёр том улсын (БНХАУ ба ОХУ) дунд хавчуулагдсан байрлалтай, далайд гарцгүй тул бусад улсуу хийх экспорт тус хоёр улсаас хамааралтай. Экспортын тээврийн зардал өндөртэй тул агаарын тээврээр хийх экспортын бүтээгдэхүүний үнэ нэмэгддэг, энэ нь эргээд тус бүтээгдэхүүнүүдийн өрсөлдөх чадварыг бууруулдаг. - Дэд бүтцийн сул хөгжил экспорт хийхэд сөргөөр нөлөөлдөг.

- **Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ цэний сүлжээний үе шатуудад тулгамдсан асуудлууд**
 - Стандарт, зохистой дадлуудын мөрдөх байдал хангалтгүй
 - Дэд бүтцийн сул хөгжил
 - Бүтээмж багатай, хаягдал ихтэй
 - Техник, технологийн хоцрогдол
 - Мал, амьтны халдварт өвчин, худалдааны хориг саад
 - Бодлогын болон хөрөнгө оруулалтын зөрүү
 - Уур амьсгалын өөрчлөлт

• Санал

• Үйлдвэрлэлийн шатанд:

- Малын эрүүл мэндийн статусыг сайжруулах, үүнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх
- Малын чанар, бүтээмжийг сайжруулах, малчдын хандлагыг өөрчлөх

• Логистикийн шатанд:

- Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлэлтийн тогтолцоо, сүлжээг хөгжүүлэх

• Боловсруулах шатанд:

- Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар боловсруулах үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулахад анхаарах
- Малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх

• Санал

• Экспорт, борлуулалтын шатанд:

- Худалдаа, экспорт, маркетинг, мөшгөх тогтолцоонд блокчэйн технологи нэвтрүүлэх талаар дэмжлэг үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах
- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, чөлөөт худалдааны бүсүүдийг дэмжих замаар худалдааны тарифын болон тарифын бус хязгаарлалтуудыг хөнгөвчлөхөд анхаарах
- Улс орнууд, эдийн засгийн хамтын ажиллагааны блокуудын тарифын болон тарифын бус хязгаарлалтуудын талаар нарийвчилсан судалгаа хийх замаар экспортын цогц стратеги боловсруулж хэрэгжүүлэх

• Бодлого боловсруулах шатанд:

- Мал аж ахуйн үнэ цэний сүлжээг хөгжүүлэх цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- Малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх стратеги боловсруулж хэрэгжүүлэх

• Бүх шатанд: олон улсын стандарт, зохистой дадал



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

kadirbyek@mul.s.edu.mn
9595-5996

